



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/36

Сэнгөөцдолой

Үнэлгээний хороо байгуулах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны улсын төсвийн санхүүжилтээр хийгдэх "цэцэрлэгийн хүүхдийн хоол"-ны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга : Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга С.Нямаа (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэргэжилтэн)

Гишүүдэд: А.Отгонмаа (Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогч)

Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)

Ч.Үүрцайх (7-р багийн иргэн)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж архивад хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



102202007